



Б.БЯМБАБААТАР

*Хууль сахиулахын их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
Аюулгүй байдлын тэнхимийн ахлах багш, хөшүүч*

МАНСУУРАХ ДОНТОЙ ЭТГЭЭДИЙГ ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Нийгэм дэх өнөөгийн байдал

Монгол улс дахь мансууруулах бодисийн хэрэглээ болон энэ төрлийн гэмт хэрэгт шийтгүүлэгчдийн тоо хэрхэн өссөнийг 2014 онд хийгдсэн төрийн болон төрийн бус байгууллагаас гаргасан судалгаанаас үзвэл.

1999 онд мансуурах донтой 45 хүн байсан бол 2014 оны 11 сар буюу өнөөдрийн байдлаар 600 орчим хүн хэрэглэж байгаа гэсэн бүртгэл байна. Олон улсын жишгээр хар тамхи хэрэглэж буй нэг хүний цаана дөрвөн хүн байдаг гэж тооцдог. Монгол Улсын хэмжээнд төрийн байгууллагаас гаргасан доривтой судалгаа хийгдээгүй бөгөөд 2000 гаруй хүн мансууруулах бодис хэрэглэдэг судалгаа гарсан байна. 1995-2005 онд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой буюу мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх олж авах, хадгалах, тарих, хурааж авах үйлдлүүдтэй 63 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 152 хүн сэжигтэн, яллагдагчаар татагдсан байна. Эдгээр 63 гэмт хэргээс 60 холбогдогчтой 22 гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн ба шүүгдэгчдийн 42 нь хорих ял бусад нь хорихоос өөр төрлийн ял шийтгэл хүлээсэн байна. Мөн дээрх гэмт хэргүүдийг шалгах явцад 22,5 кг каннабис, 0,1 кг героин, 0,4 кг кокаин, 4 ширхэг амфетамин, 285 ампул морфин, 200 грам нунтаг морфин, 2500 ампул пормидол, 1475 ампул пентазоцин, 67 феназефам тус тус хураагдаж эд мөрийн баримтаар тогтоогдож байв. Үүнээс үзвэл тухайн гэмт хэрэгт шийтгүүлэгчдийн тоо мөн өссөн бөгөөд хэрэглэгчдийг дараах 4 ангилалд хамааруулан авч үзэж болох юм. Үүнд:

- Эхний бүлэгт чинээлэг айлын хүүхдүүд ордог ба тэд ихэвчлэн БНХАУ-ын хилээр хууль бусаар их хэмжээгээр нэвтрүүлэн оруулж ирдэг гашиш болон синтетик төрлийн хар тамхи, амфетамин, мансууруулах бодис хэрэглэж зуршсан байна.

- “хип хоп” урсгалын дуу хөгжим сонсдог залуучид, дуучид гашиш

болон зэрлэг өвсийг хольж хэргэлдэг.


- рок дуу, хөгжим сонирхдог залуучууд юм. Тэд нар бусад ангилалд байгаа хүмүүсийг бодвол хамгийн боломж муутай хэрэглэгч гэж тооцогддог тэд ихэвчлэн Монгол Улсын нутагт ургадаг хар тамхины төрлийн ургамлыг түүж, бэлтгэх, улмаар түүнийгээ хатааж боловсруулан татах байдлаар хэрэглэж мансуурсан тохиолдлууд цөөнгүй бүртгэгдсэн байдаг.

-Дөрөв дэх ангилалд Монгол Улсад түр болон удаан хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэд орох бөгөөд тэд хоёрдугаар ангиллын хүмүүстэй адил хэрэглээтэй байдаг. Мөн нэг хүн дунджаар 2-8 төрлийн мансууруулах бодис хэрэглэдэг.

Нийт Монгол улсын хэмжээнд 16000 ⁶⁵гэж заагдсан байдаг. 1 хэрэглэгчийн ард 4 хүн гэж үзвэл 60-аад мянган хэрэглэгчтэй. Нэг хар тамхичин жилдээ дунджаар 30-40 сая төгрөгийг тэр донтох хэрэглээндээ зарцуулдаг болсон байна.


Хар тамхинд дөнгөж орж буй хүнийг эмчлэхэд наад зах нь 8 сая төгрөг шаардагддаг юм байна. Дээрх тоо баримт бусад орнуудынхтай харьцуулахад харьцангуй цөөн мэт боловч олон улсын жишгээр 1 хэргийн ард 10 тохиолдол байдаг гэж үзвэл энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал хүндрэх төлөв ажиглагдаж байна.

Хар тамхины гэмт хэргээр шалгагдсан хүний тоо:



65 Ерөнхийлөгчийн илтгэл "Хартамхи, мансууруулах бодисын аюул – урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга зам" сэдэвт нээлттэй уулзалтанд биечлэн оролцож, хэлсэн үг.

Монгол Улсад хар тамхины гэмт хэргээр хорих ял эдлэгсэдийн тоо



1000 га газар буюу 14 аймагт мансууруулах бодис оролцсон ургамал ургадаг бөгөөд олон улсын түвшинд байдаг мансууруулах бодисыг монголд оруулж ирж, хэрэглэдэг хүний тоо ихссэн үзүүлэлт гарчээ. Одоогийн байдлаар 37 монгол иргэн гадаадад хар тамхи, мансууруулах бодисын хэрэгт холбогдон хоригдож байна.

Монгол улс дахь хар тамхины ургамалын тархац: Төвлөрсөн 23 хорих ангиудын байршил нь тухайн бүс нутаг хамрагдаж байгаа нь хорих ангид мансууруулах бодис хэрэглэх нөхцөл бололцоог бүрдүүлэх боломжтой гэж үзэж байна. Энэ асуудал нь практик байдал дээр гарч байсан бөгөөд тухай үед нь алба хаагчидийн мэдлэг чадвар муу, мансууруулах ургамал Мансууруулах бодисын хууль бус үйл ажиллагаанд оролцсон этгээдүүдэд олон жилээр хорих ял оногдуулж, бусад жирийн ялтануудтай хорих нь хорих ангиудад тухайн төрлийн гэмт хэрэг хөгжих боломж бүрдүүлэх нөхцөл олгохын зэрэгцээ гэмт этгээдүүд бие биенээсээ туршлага суралцах мөн шинэ төрлийн зах зээл нээгдэх үндэс болно гэж үзэж байна.

Монгол Улс дахь хар тамхины ургамалын тархан



Монгол Улсад мансууруулах бодисын наймаа, түүнтэй холбогдсон гэмт хэрэг өргөн тархалттай биш хэдий ч тоо нь нэмэгдэж, төр засгийн анхаарлыг татаж байна. Өсөн нэмэгдэж буй мансууруулах бодисын наймаанд ялангуяа Монголын хот, суурин газрын өсвөр үе, залуучууд их өртөж байгаа тулгамдсан асуудал юм. Засгийн газраас 2000 онд баталсан Мансууруулах бодистой тэмцэх хөтөлбөр хэрэгжиж байна. Анх батлагдсан 5 жилийн төлөвлөгөө 2005 онд дуусгавар болсон хэдий ч дараачийн шатанд ямар өөрчлөлт хийхээ Засгийн газар хараахан шийдээгүй байна. Цагдаагийн даргын ахалдаг Үндэсний Зөвлөл нь энэ хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулдаг бөгөөд уг хөтөлбөр нь мансууруулах бодистой тэмцэх хууль эрх зүйн үндсийг бий болгож, мансуурлын эсрэг бодлого явуулан, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх замаар донтолт, гэмт хэргээс сэргийлэх шаардлагатай гэж үзэж байна.

Хорих байгууллагын чиглэлээр суралцаж байгаа сонсогч, оюутан, алба хаагчдын мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх энгийн аргаар хэрхэн таних аргад сургах, ял эдлүүлэх ажиллагаанд шинжлэх ухаан, технологийн ололт амжилтыг бүрэн дүүрэн ашиглах чадвартай болох албаны нохойг мансууруулах бодис илрүүлэх ажиллагаанд ашиглах саналтай байна.

* Үндэсний аюулгүй байдлыг хангах байгууллагууд болон мансуурах сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн эргэлтэнд хяналт тавих чиг үүрэг

бүхий байгууллагуудын үйл ажиллагаа, гүйцэтгэх ажлыг нэгтгэх мэдээлэл солилцох хяналт тавих чиглэлээр хамтран ажиллах.

* Мансуурах донтой этгээдийг ял эдлүүлэх нөхцөлийг тодорхой зааж тэндэнд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээг боловсронгуй болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх.

* Тодорхой тооны албан хаагчдыг мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн талаар мэрэгшүүлж, сургалтанд хамруулах.